



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/80

Алтрага

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, 33 дугаар зүйл, сумын ИТХ-ын 2023 оны ээлжит ХИУ хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр явагдсан газар эзэмшүүлэх эрхийн бичгийн дуудлага худалдаагаар өндөр үнэ өгч ялсан Монгол Улсын иргэн Д.Нямбат (РИ91032417)-д Эмт багийн нутаг Цагаан булангийн "3 салаа гарамны хажуу"-д 1477 м2 газрыг амралтын (Zipline), М.Эрдэнэчулуун (PB82071400)-д Хайс багийн нутаг "Шар булан" амралт-06-д 466 м2, Ө.Нарантуяа (PB72060801)-д "Шар булан" амралт-07-д 665 м2, М.Билгүүн (ГЮ89030386)-д "Шар булан" амралт-08-д 517 м2, Б.Оргил (УК91081138)-д Тоом багийн нутаг: Самын булангийн эх" амралт-01-д 1963м2 газрыг амралтын газрын зориулалтаар 20 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшүүлсүгэй.

2.Захирамжаар газар эзэмшигчидтэй тус тус газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Д.Батсайхан), улсын бүртгэгч (Н.Азжаргал) нарт зөвшөөрсүгэй.

3.Сумын Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг сумын Газрын даамал (Д.Батсайхан)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010184